

ТАНИЛЦУУЛГА

Аж ахуйн нэгжийн орлогын албан
татварын тухай хуульд нэмэлт оруулах
тухай хуулийн төслийн тухай

Үндэсний Статистикийн газрын тархаасан мэдээллээс Монголд ажилгүйдлийн түвшинд дунджаар 7 орчим хувьтай байдаг нь олон улсын дундажтай ойролцоо байна. Харин цалин хөлстэйгээр ажиллаж буй 1.1 сая ажилтны хувьд 2021 оны байдлаар дундаж цалин 1,279.4 мянган төгрөг, медиан цалин 951.4 мянган төгрөг байна. Эдгээр нь олон улсын хувьд дундаж цалин 482\$, медиан утга 226\$ гэсэн тоо баримтууд байдаг аж. Харин Монголд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 120\$ байгаа нь дэлхийн дунджаас 3,5 дахин, медиан хэмжээнээс 2 дахин, хамгийн өндөр хэмжээтэй улс болох Швейцар улсаас 30 дахин бага утгатай байна.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь инфляцийн түвшин, амьдралын өртөгтэй холбоотой өөрчлөгдөж байдаг ч Монголд уг хэмжигдэхүүнийг “нэгж хүн ядуурлаас ангид хүнс тэжээл, хороход байр олж амьдрах ядуурлын ирмэг тоо” болгон авч үздэг. Мөн ажил хийж буй Монголын нэг иргэний ард дунджаар 1,6 хүн буюу ойролцоогоор 2 хүн түүнээс хамааралтайгаар амьдарч байгаа статистик тоо баримтууд байна. Энэ нь нэгж цалин бүрийн цаанаа 3 хүний амьжиргааг байгааг илтгэнэ.

Сүүлийн 2 жилийн туршид үргэлжилсэн цар тахлаас үүдсэн нийлүүлэлтийн тасалдал, бараа материалын хомсдлоос шалтгаалсан үнийн өсөлт үргэлжилсээр байна. Зөвхөн он гарснаас хойш инфляцийн түвшин 14,4 хувьд хүрч, валютын нөөц 1,2 тэрбуумаар багасч энэ хэрээр иргэдийн худалдан авах чадвар, амьжиргааны түвшинд эрсдэл үүсч байна. Гэвч энэ бүхэн нь угаас баттайгаар бэхжиж чадаагүй дундаж давхарга, нийгмийн бүлгүүд, аж ахуйн нэгжүүдэд улам их дарамт үзүүлэхээр байна.

Мөн иргэд, залуучуудын зүгээс орлого, цалинг өсгөх шаардлагыг тавьсан тайван жагсаалыг саяхан хийсэн. Үндсэн Хуулийн 5.2-д бид “нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаалах”-аар зааж өгсөн. Ийм зүй ёсны шаардлага, үндэслэлүүд бий учраас бизнесүүдийн орлого, ашгийг нэмэгдүүлэх, ажилтнуудын цалин хөлсийг өсгөх чиглэлд төр засаг тодорхой хэмжээгээр анхаарч байгаа. Гэвч хувийн хэвшлийн байгууллагуудыг цалингаа өсгө, нэм хэмээн шаардах нь зохимжгүй учраас тэдэнд цалингаа өсгөх боломжийг бүрдүүлэх, сэдэл сонголтыг бий болгох нь зүйтэй хэмээн үзэж энэхүү хуулийн төслийг санаачлан боловсрууллаа.

Хуулийн төсөлтэй холбоотойгоор иргэд, олон нийтээс санал авахаар 2022 оны 4 сарын 21 өдөр d.parliament сайт болон өөрийн сошиал хуудсаар хандсан бөгөөд санал ирээгүй болно.